# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 08 өдөр    Дугаар 360    Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны ''Зөвшөөрөл олгох тухай'' 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн нийт 2,278,866,891.84 (хоёр тэрбум хоёр зуун далан найман сая найман зуун жаран зургаан мянга найман зуун ерэн нэгэн төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 1,873,908,024.71 (нэг тэрбум найман зуун далан гурван сая есөн зуун найман мянга хорин дөрвөн төгрөг далан нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу ''Засгийн газрын автобааз'' улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.''Засгийн газрын автобааз'' улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, ''Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд''-д бүртгэх;

2.3 Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА    Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА    Д.НАРАНГЭРЭЛ

132002883

\Huraldaanii material\2022 on\2022.09.08 20-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 09... дугаар сарын 08 өдрийн
360...дугаар тогтоолын хавсралт

## "ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| д/д | Шилжүүлэн өгөх хуулийн этгээдийн нэр | Автомашины нэр, марк | Улсын бүртгэлийн | | Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он | | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэх өртөг (төгрөг) | Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг) | Цаашид ашиглах хугацаа (жил) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сери | Дугаар | | | | | | | |
| 1 | Эдийн засаг, хөгжлийн яам | Соната7 | УНҮ | 05-30 | 2013 | 2013 | 14,000,000.00 | 10,499,999.90 | 3500000.10 | | |
| 2 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Лексус 570 | УНБ | 07-08 | 2015 | 2015 | 215,000,000.00 | 189,573,401.16 | 25426598.84 | | |
| 3 | Барилга, Хот Байгуулалтын яам | Хьюндай Соната 7 | УНҮ | 05-79 | 2013 | 2013 | 10,755,065.00 | 10,755,065.00 | 0.00 | 30,000,000.00 | 2 |
| 4 | Барилга, Хот Байгуулалтын яам | Хьюндай Соната 7 | УБҮ | 04-53 | 2013 | 2013 | 10,429,137.00 | 10,429,137.00 | 0.00 | 30,000,000.00 | 2 |
| 5 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | Тоёота Лексус LX570 | УБЯ | 23-00 | 2013 | 2013 | 124,000,000.00 | 124,000,000.00 | 0.00 | 30,000,000.00 | 2 |
| 6 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | Хьюндай Соната 7 | УБҮ | 03-84 | 2013 | 2013 | 14,200,000.00 | 14,200,000.00 | 0.00 | 30,000,000.00 | 2 |
| 7 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Тоёота приус 30 | УНЗ | 82-08 | 2015 | 2020 | 21,062,164.84 | 3,510,360.80 | 17551804.04 | | |
| 8 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Тоёота приус 41 | УАМ | 82-09 | 2013 | 2019 | 20,000,000.00 | 4,000,000.08 | 15999999.92 | | |
| 9 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Тоёота приус 50 | УНЗ | 03-93 | 2017 | 2019 | 45,000,000.00 | 9,000,000.00 | 36000000.00 | | |
| 10 | Хөдөлмөр,нийгмийн хамгааллын яам | Ниссан теана | УНҮ | 24-20 | 2016 | 2016 | 64,000,000.00 | 12,799,999.92 | 51200000.08 | | |
| 11 | Хөдөлмөр,нийгмийн хамгааллын яам | Соната-7 | УНА | 01-19 | 2013 | 2013 | 41,000,000.00 | 40,316,666.62 | 683333.38 | | |
| 12 | Хөдөлмөр,нийгмийн хамгааллын яам | Nissian teana | УБИ | 93-56 | 2013 | 2014 | 55,000,000.00 | 46,444,444.24 | 8555555.76 | | |
| 13 | Хөдөлмөр,нийгмийн хамгааллын яам | Соната-7 | УББ | 27-94 | 2014 | 2014 | 61,694,600.00 | 39,835,243.65 | 21859356.35 | | |
| 14 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Тоёота Ланд 00-36 | УНМ | 00-36 | 2010 | 2013 | 117,645,000.00 | 117,645,000.00 | 0.00 | 30,000,000.00 | 2 |
| 15 | Боловсрол, шинжлэх ухааны яам | Лексус 570 | УБЛ | 01-45 | 2012 | 2012 | 189,000,000.00 | 189,000,000.00 | 0.00 | 30,000,000.00 | 2 |
| 16 | Боловсрол, шинжлэх ухааны яам | Ниссан Патрол Y62 | УНҮ | 99-06 | 2013 | 2013 | 173,850,000.00 | 173,850,000.00 | 0.00 | 30,000,000.00 | 2 |
| 17 | Ашигт малтмал, газрын тосны газар | Ниссан Патрол | УНН | 10-81 | 2015 | 2016 | 88,560,300.00 | 75,957,355.80 | 12602944.20 | | |
| 18 | Ашигт малтмал, газрын тосны газар | Ниссан Патрол | УНТ | 08-91 | 2015 | 2016 | 85,000,000.00 | 74,375,000.28 | 10624999.72 | | |
| 19 | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар | Тоёота ланд круйзер 200 | УНЦ | 77-72 | 2013 | 2017 | 124,999,875.00 | 124,999,875.00 | 0.00 | 30,000,000.00 | 2 |
| 20 | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар | Тоёота ланд круйзер 200 | УНҮ | 08-29 | 2013 | 2017 | 86,000,000.00 | 86,000,000.00 | 0.00 | 30,000,000.00 | 2 |
| 21 | Нийгмийн даатгалын ерөнхий газар | Sonota-8 | УНҮ | 07-30 | 2015 | 2016 | 54,900,000.00 | 41,175,000.00 | 13725000.00 | | |
| 22 | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар | Рено Логан | УБО | 03-51 | 2018 | 2019 | 33,600,000.00 | 11,760,000.00 | 21840000.00 | | |
| 23 | Улсын бүртгэлийн ерөнхий газар-Төв аппарат | Киа серато | УБҮ | 41-87 | 2013 | 2018 | 54,100,000.00 | 16,229,999.88 | 37870000.12 | | |
| 24 | Цаг уур, орчны шинжилгээний газар | Хьюндай Соната-7 | УНҮ | 05-76 | 2012 | 2013 | 36,850,000.00 | 36,850,000.00 | 0.00 | 30,000,000.00 | 2 |
| 25 | Иргэний нисэхийн ерөнхий газар | Тоёота Ландкруйзер 105 | УБД | 00-79 | 2007 | 2007 | 57,134,000.00 | 57,134,000.00 | 0.00 | 30,000,000.00 | 2 |
| 26 | Харилцаа холбооны зохицуулах хороо | Ниссан теана | УБҮ | 34-63 | 2016 | 2017 | 59,900,000.00 | 48,252,777.52 | 11647222.48 | | |
| 27 | Санхүүгийн зохицуулах хороо | Хьюндай Соната-7 | УНҮ | 07-46 | 2012 | 2012 | 37,086,750.00 | 37,086,750.00 | 0.00 | 30,000,000.00 | 2 |
| 28 | Төв аймгийн Төрийн аудитын газар | Киа К-5 суудлын автомашин | ТӨВ | 00-57 | 2013 | 2016 | 30,000,000.00 | 25,000,000.20 | 4999999.80 | | |
| 29 | Онцгой байдлын ерөнхий газрын харьяа -Ар талын 115-р анги | Соната-7 | УНА | 62-15 | 2013 | 2013 | 28,000,000.00 | 6,999,999.96 | 21000000.04 | | |
| 30 | Монгол Улсын Боловсролын их сургууль | Тоёота рав 4 | УБЗ | 72-33 | 2017 | 2017 | 98,000,000.00 | 40,016,666.83 | 57983333.17 | | |
| 31 | Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төв | SANOTA 7 4F | УНА | 80-97 | 2012 | 2013 | 34,900,000.00 | 34,900,000.00 | 0.00 | 30,000,000.00 | 2 |
| 32 | Улаанбаатар МХС ХК | NISSAN TEANA | УНҮ | 08-52 | 2016 | 2016 | 59,900,000.00 | 39,220,238.20 | 20679761.80 | | |
| 33 | Монгол-Ус ТӨҮГ | Тоёота Ланд круйзер 200 | УБН | 01-22 | 2015 | 2019 | 100,000,000.00 | 35,934,286.50 | 64065713.50 | | |
| 34 | Автотээврийн үндэсний төв | Соната-7 | УБЗ | 04-49 | 2014 | 2016 | 54,700,000.00 | 46,343,055.39 | 8356944.61 | | |
| 35 | Монгол Улсын Хөгжлийн банк | Хюндэй Соната-7 | УНҮ | 94-21 | 2013 | 2013 | 41,200,000.00 | 37,022,777.78 | 4177222.22 | | |
| 36 | "МИАТ" ТӨХК | ХЮНДАЙ ЖЕНЕСИС | УНН | 47-74 | 2015 | 2019 | 35,000,000.00 | 14,550,923.00 | 20449077.00 | | |
| | Нийт дүн | | | | | | 2,278,866,891.84 | 1,873,908,024.71 | 490,798,867.13 | 390,000,000.00 | - |
| | | | | | | | (хоёр тэрбум хоёр зуун далан найман сая найман зуун жаран зургаан мянга найман зуун ерэн нэгэн төгрөг наян дөрвөн мөнгө) | (нэг тэрбум найман зуун далан гурван сая есөн зуун найман мянга хорин дөрвөн төгрөг далан нэгэн мөнгө) | (дөрвөн зуун ерэн сая долоон зуун ерэн найман мянга найман зуун жаран долоон төгрөг арван гурван мөнгө) | (гурван зуун ерэн сая) | |